

## УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**ХЯТАДЫН УДИРДЛАГААС АФРИКИЙН СОЦИАЛИСТ  
ЧИГ БАРИМЖААНЫ ОРНУУДЫН ТАЛААР  
БАРИМТАЛЖ БУЙ ЧИГ ШУГАМ****3. Эрдэнэчимэг**

Орчин үед шинэ тулгар хөгжиж байгаа орнууд улс төрийн талаар тусгаар тогтнолоо бататган бэхжүүлэх үндсэн дээр эдийн засгийн талаар биеэ даах, нийгмийн дэвшилт өөрчлөн байгуулалт хийхийн төлөө тэмцэх боллоо.

Энэ тухай 1969 онд Москвад хуралдсан олон улсын коммунист, ажилчны намуудын Зөвлөгөөний Үндсэн баримт бичигт: «Манай үеийн хувьсгалт нөхцөл байдлын нөлөөгөөр чөлөөлөгдсөн орнуудын дэвшилт хөгжлийн өвөрмөц хэлбэрүүд гарч, хувьсгалт ардчилсан хүчний үүрэг их болов. Шинэ тулгар зарим улс хөгжлийн капиталист биш зам—колонийн үеэс улиран үлдсэн хоцрогдлыг арилгаж, социалист хөгжилд шилжих нөхцөлийг бүрдүүлэх боломжийг хангах замд оров. Эдгээр орны социалист чиг баримжаа нь ихээхэн бэрхшээл, сорилтыг даван туулж өөртөө зам гаргаж байна. Эдгээр улс империализм, шинэ колончлолын эсрэг шийдвэртэй тэмцэж байна»<sup>1</sup> гэж тэмдэглэжээ. Шинэ тулгар хөгжиж буй орнуудад дотоод, гадаад бодлогоо хэрэгжүүлэхэд нь социалист хамтын нөхөрлөлийн зүгээс интернационалч бүх талын тусламж дэмжлэг байнга үзүүлж байгаа нь онцгой ач холбогдолтой юм.

Одоо Африкт Алжир, Гвиней, Конго, Танзани, Гвиней-Бисау, Ногоон Хошууны арал, Ангол, Мозамбик, Бенин, Мадагаскар, Этиоп зэрэг орон хөгжлийн социалист чиг баримжааг сонгон авч, нийгэм—эдийн засгийн хувьсгалт өөрчлөлт хийж байна. Ингэхээр эдгээр улс орон БНМАУ-ын капиталист биш хөгжлийн замын түүхэн туршлагыг сонирхох болсон нь зүй ёсны хэрэг билээ.

Гэтэл Хятадын эрх баригчид Африкийн шинэ тулгар орнуудын хөгжлийн капиталист биш замыг сонгон авч байгааг таашаахгүй байна. Ер нь Хятадын удирдлага капиталист биш хөгжлийн замыг «колоничлолын зам»<sup>2</sup> «хөгзрөн ялзарсан таваарын зам»<sup>3</sup> хэмээн нэрлэж, тухайлбал БНМАУ-ын капиталист биш хөгжлийн түүхэн туршлагыг элдвээр муулах, мушгин гуйвуулахыг ямагт оролдож ирсэн нь санамсаргүй билээ. Хятадын удирдлага капиталист биш хөгжлийн замын түүхэн туршлагыг гуйвуулах, үгүйсгэх үзэл баримтлаад зогсоогүй бас социалист чиг баримжааг нэгэнт сонгон авсан орнуудын эсрэг

1. Олон улсын коммунист, ажилчны намуудын Зөвлөлгөөн баримт бичгүүд. УБ., 1969. 33-р тал
2. «Жэньминь жибао», 1967. Х. 17
3. «Жэньминь жибао», 1967. Х. 20.

дайсагнасан ажиллагаа үйлдэж байгаа үйл явдал харуулж байна. Бээжингийн удирдлага социализм байгуулах «Хятадын зам» гэгчийн Африкийн шинэ тулгар орнуудад жинхэнэ социализмын «үлгэр загвар» болгон харуулахыг эрмэлзэж ирэв. Чухамдаа социализмын онцлог шинж, шалгуурын тухай маогийнхны томёолол «Хятадчилагдсан марксизм» гэгчид гол суурь эзэлж байгаа бөгөөд энэ нь бодит социализмын болон социалист чиг баримжаагаар хөгжиж буй орнуудтай харилцах харилцааны нь үндэс болж байна.

70-аад оноос Хятадын эрх баригчид «гурван ертөнцийн онол»\* гэгчээ дэвшүүлж гаргасан бөгөөд энэхүү «онол» нь социализм болон зөвлөлтийн эсрэг чиг шугам, дэлхийн хувьсгалт хөдөлгөөнд хандах Хятадын их гүрний дээрэнгүй үзлийн үндэслэл болсон юм. Мөн түүнчлэн БНХАУ-ыг «гурав дахь ертөнцөд» хамааруулсан нь шинэ тулгар хөгжиж буй орнуудыг бодит социализмын орнуудаас холдуулж, улмаар ЗХУ ба ах дүү бусад орны эсрэг тэмцэлдээ ашиглах зорилго тавьсан нь тодорхой болов.

Хятадын удирдлага «хоёр хэт их гүрэн»--ЗСБНХУ, АНУ-ын эсрэг тэмцэж байгаа мэт өргөн сурталчилдаг боловч үнэн хэрэгтээ тэмцлийнхээ голыг ЗХУ-ын эсрэг чиглүүлж, харин өөрөө АНУ тэргүүтэй империалист улсууд, харгис хүчинтэй улам бүр ойртож байгааг бодит амьдрал харуулж байгаа билээ. Ийнхүү Хятадын эрх баригчид дэлхийн харгис хүчнийг ил, далд янз бүрээр дэмжин, империализмын эрх ашигт үйлчлэх болсныг Ангол, Этиоп, Сомали, Египет зэрэг орнуудад тэдний явуулж буй бодлого гэрчилж байна. Хятадын удирдлага социалист чиг баримжаагаар хөгжиж буй орнуудад ялгавартай хандаж байгааг бас анхааран ажиггүй байж болохгүй.

Ангол, Этиоп, Мозамбик зэрэг орон социалист чиг баримжааг сонгон аваад төдий удаагүй боловч тэнд дэвшилт өөрчлөлт нэлээд тууштай хэрэгжиж байгаагаас гадна марксизм—ленинизмын үзэл санаа, ажилчин ангийн намын зарчмыг удирдлага болгоно гэж тунхагласан хөдөлмөрчдийн манлай—хувьсгалт ардчилсан нам төлөвшин бэхжиж байна. Гэтэл эдгээр орны эсрэг Хятадын эрх баригчид империалист хүчнүүдтэй нэгдэн, хууль ёсны засгийг нь түлхэн унагаах, хувьсгалын эсэргүүчүүдийг өдөөн хатгах зэрэг бараг шууд дайсагнасан бодлого явуулж байна. Тухайлбал, Бээжингийн удирдагчид Анголын ард түмний улс төрийн манлай нам—Анголыг Чөлөөлөхийн төлөө Ардын Хөдөлгөөн (МПЛА) Хөдөлмөрийн намын эсрэг «Анголыг чөлөөлөх Үндэсний фронт» (ФНЛА), «Анголын төгс Тусгаар тогтнолын төлөө Үндэсний холбоо» (УНИТА) зэрэг империализмын гар хөл болсон тоглоомын байгууллагын янз бүрийн аргаар дэмжиж, ингэснээрээ Анголын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож ирэв.

Хятадын эрх баригчид бас Египет—Ливи, Сомали—Этиоп, Заир—Анголын хооронд гарч байсан хилийн мөргөлдөөнийг улам дэвэргэх, шинэ шинэ маргаан дэгдээх зэрэг явууллага хийж байлаа. Ялангуяа Этиоп—Сомалийн хооронд гарсан маргааныг тэд ашиглахдаа өөрт нь таалагдаагүй Этиопийн дэвшилт хүчнийг устгахыг оролдож, Сомалид 20 сая долларын зээллэг болон цэрэг зэвсгийн тусламж үзүүлж байв. Үүний хамт Этиопоос Эритрей мужийг салгахаар оролдож байсан салган тусгаарлагчдыг тэд бас дэвэргэн дэмжиж байлаа.

\*Мао Зэдун 1974 онд энэ онолын сэдвийг дэвшүүлжээ. «Нэг дэх ертөнцөд» АНУ, ЗСБНХУ-ыг, хоёр дахь ертөнцөд» Англи, Герман, Өрнөд Герман, Япон, Австрали, Шинэ Зеланд, Канад зэрэг хөгжингүй хөрөнгөтөн орнууд, Европын социалист орнуудыг, гуравдахь ертөнцөд Ази, Африк, Латин Америкийн орнуудыг тус тус оруулж байна. Жэньминь жибао» сонины редакцийн өгүүлэл. Тусгай хэвлэл. Бээжин. 1974. 4-р тал.

Хятадын эрх баригчдаас Африкийн социалист чиг баримжаат орнуудад өөрийн нөлөө, улс төрийн шахалтаар бэхжүүлэх гол арга нь худалдаа, эдийн засгийн харилцааг ашиглаж байгаа явдал юм. Сүүлийн үед Египет, Сомали, Заир, Судан, Танзани зэрэг орнуудтай худалдаа—эдийн засгийн өргөн харилцаатай байна.

Хятадын «тусламжийг» авч байгаа орнуудад уг тусламжийн хэмжээний тал хувьд нь Хятадын өргөн хэрэгцээний барааг оруулан өгч, тухайн орны зах зээл дээр борлуулах болзол тавьдаг байна. Мөн түүнчлэн Африкийн орнуудад Хятад гол төлөв хөнгөн үйлдвэр, спортын иж бүрэн цогцолбор, зам гүүр барьж өгдөг бөгөөд Хятадын тусламжаар баригдсан дээрх барилга байгууламжууд нь хоцрогдсон арга барил бүхий хуучирсан техникээр тоноглогдсон байдаг байна. Тухайлбал, Хятадын тусламжаар Танзанид барьсан «ТАНЗАМ» төмөр зам ашиглалтанд орсон цагаас хойш осол гэмтэлд орж, түүнийг засварлах ажилд ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө зарж байгаа нь энэ улсын эдийн засагт багагүй хохирол учруулжээ. «ТАНЗАМ» төмөр замыг тавьснаар Танзани, Замби, Ботсван, Заир зэрэг орнуудад чөлөөтэй нэвтэрч, эдгээр орны эдийн засгийг өөрийн хяналтанд авах зорилготой юм. Энэ бүх байдлаас үзэхэд Хятадаас Африкийн орнуудад үзүүлж буй эдийн засгийн «тусламж» нь хэрэг дээрээ тухайн орнуудаас түүхий эд олж авах, өөрийн барааг борлуулах тогтвортой зах зээлтэй болох зорилготойгоос биш, тэдгээр орны эдийн засгийн биеэ даасан байдалд тус дөхөм үзүүлэх, улс ардын аж ахуйн чухал салбаруудыг байгуулахад төдийлөн нэмэр болохгүй байгаа бөгөөд энэ талаар ч Африкийн орнуудын зарим нэг хэвлэлд илэрхий бичиж байгаа юм.

Сүүлийн үед Хятадын удирдлага Египет, Сомалитай харилцаагаа улам өргөжүүлэх бодлого явуулах боллоо. Энэ хоёр оронд хувьсгалт үйл явц ахицгүй болж, социалист чиг баримжааны замаас ухарсан явдлыг Хятадын удирдагчид овжин ашиглаж тэдэнтэй ойртох болжээ.

1982 оны эцэс, 1983 оны эхээр БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жао Зыян Африкийн арав гаруй орноор «айлчлах» үедээ Египетэд очиж тус орны удирдлагад 400 сая долларын зээл олох, нэг бүр нь 1 сая долларын үнэ бүхий Ф—7 маягийн онгоц 70 ширхэгийг өгөхөөр амлажээ. Мөн Сомалид 200 мянган ам.дөрвөлжин км талбайд 57 барилга байгууламж барьж, 1984 оны эцэст дуусгахаар төлөвлөжээ.<sup>4</sup>

Африкийн өмнөд хэсэгт колоничлолын үлдэгдэл хэвээр оршсоор байгаа бөгөөд энэ нь зөвхөн Африкт төдийгүй манай гаригийн хамгийн түгшүүрт хэсгийн нэг болж байна. Хятадын удирдагчид Өмнөд Африкийн цөөнх цагаан арьстнуудын харгис эрх баригчидтай аль эртнээс түншилж, тэдэнд улс төр, санхүүгийн тусламж үзүүлж байгаа нь өмнөд Африкийн арьсны үзэлт дэглэмээс хөрш зэргэлдээ тусгаар тогтносон, нийгмийн дэвшилт замаар замнаж буй орнуудын эсрэг явуулж байгаа балмад ажиллагааг дэмжиж байгааг гэрчилж байна.

Өмнөд Африкийн эрх баригчид Ангол, Зимбабве, Мозамбик, Танзани зэрэг социалист чиг баримжаагаар хөгжиж буй орнуудад байнга заналхийлж, түрэмгий ажиллагаа үйлдсээр байгаа билээ. Энэ талаар Мозамбикийн ерөнхийлөгч Самора Машел тэмдэглэж хэлэхдээ: «ӨАБНУ-ын хил хязгаарын ойролцоо шинэ тулгар улс байгуулагдаж, шинэ чөлөөт, шударга социалист нийгэм байгуулж, тэр нь

энэхүү бүс нутгийн бусад оронд үлгэр дууриал үзүүлж байгаагаас айсандаа тэгэж байна»<sup>5</sup> гэжээ.

Хятадын эрх баригчдын үзэл санаа, номлол, үйл ажиллагаа нь нийгмийн дэвшлийн бодит зүйл тогтол, марксист—ленинист сургаалд харш юм. Хятадын удирдлага Африкийг нөлөөнийхөө онцгой бүс болгон хувиргаж, түүнийг дэлхийн социалист хамтын нөхөрлөлд сэргүүлэн тавих, чөлөөлөгдсөн орнуудын дотоодын харгис хүчнийг дэмжих, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн дэх империализмыг эсэргүүцсэн чиглэлийг нь алдагдуулах, тус бүс нутагт мөргөлдөөний шинэ шинэ голомт бий болгох чиг шугам баримталж байна. Энэ нь Африкийн социалист чиг баримжаат орнуудаас улс төр, эдийн засгийнхаа биеэ даасан байдлын төлөө, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахын төлөө, шинэ колончлолын хүчирхийллийн эсрэг явуулж буй тэмцэлд бодит саад учруулсаар байна.

Капиталист биш замаар хөгжин социализмд аажмаар шилжин орох зорилтыг хэрэгжүүлэх үйл явцад орон тус бүрийн хувьд зайлшгүй шаардлагатай нэг чухал нөхцөл бол дэлхийн социализм, олон улсын ажилчны хөдөлгөөнтэй нягт хамтран ажиллах явдал мөн билээ. Үүнийг гуйвуулахыг оролдож байгаа Хятадын удирдлагын гадаад бодлогод ЗХУКН-ын XXVI их хурлаас зарчмын дүгнэлт өгсөн юм. Тус их хуралд тавьсан ЗХУКН-ын Төв Хорооны тайлан илтгэлд: «БНХАУ-ын сүүлийн хорин жилийн доторхи нийгэм—эдийн засгийн хөгжлийн туршлага нь социализмын зарчмыг болон түүний мөн чанарыг дотоод, гадаад бодлогод мушгин гуйвуулах явдал юунд хүргэдгийг харуулсан хатуу сургамж боллоо»<sup>6</sup> гэж онцлон тэмдэглэжээ.

Африкийн социалист чиг баримжаат орнууд хөгжил дэвшлийн замаар замнахдаа, ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой найрамдал харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлж байдгаараа өөрсдийн орны хувьсгалт өөрчлөн байгуулалтад амжилт олж, улс төр, эдийн засгийн талаар бүрэн тусгаар тогтнох, нийгмийн амьдралыг социалист ёсоор өөрчлөн шинэчлэх тэмцлийг өөрсдийн хөгжлийн хэтийн төлөв болгож байна.

## ПОЛИТИКА КИТАЯ В ОТНОШЕНИИ АФРИКАНСКИХ ГОСУДАРСТВ СОЦИАЛИСТИЧЕСКОЙ ОРИЕНТАЦИИ

(Резюме)

Руководители Китая в своей политике учитывают и изменения тактике империализма, которые происходят в отношении стран Социалистической ориентации с 60-х годов.

В своих теоретических концепциях маоисты никогда не признавал марксистско-ленинскую теорию некапиталистического пути развития развития освободившихся государств по пути социалистической ориентации. Более того, они настойчиво боролись и борются против нее пытаясь дискредитировать ее в глазах народов Африки.

В 70-х годах китайское руководство провозгласило свою анти-марксистскую теорию «трех миров», сердцевину которой составляет программа объединения под идейной эгидой Китая всех возможных

5. «За рубежом», 1982. № 40

6. ЗХУКН-ын Төв Хорооны тайлан, намын дотоод гадаад бодлогын ээлж зорилт. УБ., 1981. 17-р тал.

сил, в первую очередь сил империализма и реакции, в широчайший международный «единый фронт» для борьбы против СССР и других стран социалистического содружества, для осуществления гегемонистских целей Пекина.

Китай проводит враждебный курс в отношении стран социалистической ориентации, используя «дифференцированный подход для осуществления своей раскольнической деятельности. В целях достижения своего враждебного курса китайское руководство учитывает ряд факторов, характеризующих сущность внутреннего положения и внешней политики этих стран. К таким факторам относятся: политическая ориентация развития данной страны; наличие правящей партии, стоящей на позициях научного социализма или же ближе к этой позиции; отношения между правящей революционно-демократической партией и коммунистической партией в ней; степень развития отношений со странами социалистического содружества и др.

Политика Китая в целом направлена против использования странами социалистической ориентации накопленного опыта реального социализма, на консервацию экономической отсталости освобожденных государств, унаследованной от империализма.

На выработку китайского курса оказывают заметное влияние политические, торговые-экономические интересы самого Пекина. Китайское руководство стремится навязать Африканским странам свои идейно-теоретические концепции, направить их политику в русло своего великодержавного курса, закрепиться в стратегически важных местах и получить свободный доступ к их рынкам и сырьевым ресурсам.

Пекин стремится также использовать в своих интересах действия империализма и сил реакции по дестабилизации положения в африканских странах, пытаясь разжечь серьезные конфликты. Главная цель этой политики направлена на усиление напряженности в африканском континенте и в мире.